Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
Т О Г Т О О Л

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Дугаар ... | Улаанбаатар хот

Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 24.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.”Журам батлах тухай” Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2-т доор дурдсан агуулгатай 2.1 дэх хэсэг нэмсүгэй.

1/2.1 дэх хэсэг:

“2.1.Төрийн өмчийн орон сууцыг хөлслөх, өмчлөх иргэдийн сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан “Төрийн өмчийн орон сууцыг иргэдэд өмчлүүлэх, хөлслүүлэх сонгон шалгаруулалтын цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлж, улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр тогтсугай.

2.Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн орон сууцыг иргэнд хөлслүүлэх, өмчлүүлэх журам”-д доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт, дэд заалт тус тус нэмсүгэй.

1/1.6 дахь хэсэг:

“1.6.Аймаг, сумын төвд байгаа орон нутгийн өөрийн өмчийн орон сууцыг иргэнд хөлслүүлэх, өмчлүүлэхэд энэ журмыг дагаж мөрдөж болно.”

2/1.7 дахь хэсэг:

“1.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга Өрийн удирдлагын тухай хуулийн 12.3-т заасан зориулалтаар өр үүсгэж барьсан орон нутгийн өмчийн орон сууцыг хөлслүүлэх, өмчлүүлэх, орон сууцанд түр суурьшуулах ажлын хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт тайлагнана.”

3/3.4 дэх хэсэг:

“3.4.Энэ журам хэрэгжиж эхлэхээс өмнө төрийн өмчийн орон сууц хөлслөн амьдарч байгаа иргэний орон сууц хөлсөлсний төлбөрийн хэмжээг тогтоохдоо мөн журмын 3.1-д заасан төлбөрийн хэмжээг, өмчлөлд шилжүүлэх нөхцөлтэй орон сууц хөлслөн амьдарч байгаа иргэний орон сууц хөлсөлсний төлбөрийг тогтоохдоо тухайн үед байгуулсан орон сууц хөлслөх гэрээг баримтална.”

4/6.5 дахь хэсэг:

“6.5. Энэ журмын 4.1-ийн 5, 8-д заасан /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний гэр бүл/ иргэдийн цахим орчинд нэвтрэх заавар зөвлөгөө өгөх, сонгон шалгаруулалтад биечлэн оролцоход дэмжлэг үзүүлэх, тэгш хүртээмжтэй үйлчилгээгээр хангах ажлыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн төслийг хариуцсан төрийн өмчит хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.”

5/6.6 дахь хэсэг:

“6.6.Энэ журмын 6.5-д заасан үйлчилгээг үзүүлэхэд мэдээлэл хариуцагч мэдээллийн эзний зөвшөөрлийг авсан байх бөгөөд сонгон шалгаруулалтад бүртгүүлэхээс өөр зорилгоор ашиглахыг хориглоно.”

6/10.1[1] дахь хэсэг:

“10.1[1] Дундаа хэсгээр өмчлөл нь төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн бүтээгдэхүүн, түүний нөхцөл, шаардлагыг үндэслэн хэрэгжинэ.”

7/10.1[2] дэх хэсэг:

“10.1[2].Дундаа хэсгээр өмчлөгч талуудын өмчлөлийг улсын бүртгэлд бүртгүүлж, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээгээр баталгаажуулна.”

8/9.1.3 дахь заалт:

“9.1.3. Дундаа хэсгээр өмчлөх гэрээний үүрэг бүрэн хэрэгжсэнээр эсхүл орон сууцны төлбөр бүрэн төлөгдсөнөөр.“

3.Мөн журмын 8.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.8 дахь заалт:

“8.8. Хөлслөх орон сууцанд хамрагдах иргэн нь даатгалын төлбөрийг сар бүр тэнцүү хуваан төлнө.”

4.Мөн журмын 7.1 дэх хэсгийн “хөлслөх” гэсний дараа “, дундаа хэсгээр өмчлөх” гэж, “цахим системээр” гэсний дараа “явуулна” гэснийг “компани болон арилжааны банктай хамтран зохион байгуулна.” гэж, 7.2 дахь хэсгийн “хөлслөх” гэсний дараа “, дундаа хэсгээр өмчлөх” гэж, 8.2 дахь хэсгийн “хөлслүүлэх,” гэсний дараа “дундаа хэсгээр өмчлөх,” гэж, 10.3 дахь хэсгийн “хөлслөх” гэсний дараа “гэрээг байгуулах ба” гэснийг “гэрээнд заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Мөн журмын 7.9 дэх хэсгийн “эхний” гэсний дараа “3” гэснийг, 8.8 дахь хэсгийн “хөлслөх” гэсний дараа “эхний” гэснийг, 2.1.2 дахь хэсгийн “байнгын” гэсний дараа “, эсхүл түр” гэснийг тус тус хассугай.

ГАРЫН ҮСЭГ